



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/100

Бөхт

Засаг даргын нөөцөөс хөрөнгө зарцуулах
тухай

Төрийн албаны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн 4.1.4, сумын Засаг даргын зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 07 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн сувилагч Борын Цэрэнпил, Нийгмийн эрүүл мэндийн ажилтан Төмөрбаатарын Үрлээ, Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш Баярхүүгийн Ану-Үжин нартай байгуулсан орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах гэрээний хэрэгжилтийг зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар хангалттай гэж дүгнэн гэрээний дагуу нутгийн тэтгэлэг 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлэг олгосугай.

2. Тэтгэлэг олгох албан хаагчдын нэрс, мөнгөн дүнгийн хэмжээг хавсралтаар баталсугай.


3. Дээрх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгийн Хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн санхүүжилтээс гаргаж, холбогдох баримтыг бүрдүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал), нярав (Т.Батбилэг) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ

Сумын Засаг даргын 2023 оны
10 дугаар сарын 23-ны өдрийн А/120
дугаар захирамжийн хавсралт



ОРОН НУТГИЙН ТЭТГЭЛЭГ ОЛГОХ
АЛБАН ХААГЧДЫН НЭРС

Д/д	Албан хаагчдын овог нэр	Албан тушаал	Регистрийн дугаар	Дансны дугаар	Олгох тэтгэлэгийн хэмжээ
1	Б.Цэрэнпил	Сувилагч	ВГ94122108	5230033209	4,443,714
2	Т.Үрлээ	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан	ЗЙ96070401	5460078396	4,994,178
3	Б.Ану-Үжин	Бага ангийн багш	ЗЙ99082509	5465066658	6,030,780
Дүн					15,468,672

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР